



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/19

Хэрлэн сум

Арга хэмжээ зохион байгуулж,  
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 2023 оны аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хорин гуравдугаар хуралдааны “Аймгийн 2024 оны төсөв батлах тухай” 02 дугаар тогтоол, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Цагаан сар-цагаан идээ 2024” нэгдсэн арга хэмжээг 2024 оны 01 дүгээр сарын 26-аас 2024 оны 01 дүгээр сарын 27-д “Чингис хотод” зохион байгуулж, 5,000,000 (таван сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.


2.Арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, шаардагдах зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Дээрх арга хэмжээнд шаардагдах зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (Ж.Энх-Амгалан)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ж.Гантулга)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны  
дүгээр сарын 15-ны өдрийн  
дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

### АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	Ж.Энх-Амгалан	Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Г.Оюун-Эрдэнэ	Хүнс, хөдөө аж ахуйн газрын Үйлдвэр, худалдаа, үйлчилгээний албаны дарга
Гишүүд:	С.Нямдаваа	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	Г.Ариунчимэг	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн бодлого хариуцсан мэргэжилтэн
	Д.Должинсүрэн	Соёлын үйл ажиллагаа, биеийн тамир, спортын бодлого хариуцсан мэргэжилтэн
	Ч.Пүрэвдорж	Стандарт хэмжил зүйн хэлтсийн дарга
	Г.Нэргүйбаатар	Биеийн тамир спортын газрын дарга
	М.Шүрэнцэцэг	Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын Захирагч
	Д.Батболд	Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын Хэнтий аймаг дахь салбарын дарга



Аймгийн Засаг даргын 2024 оны  
дүгээр сарын 15-ны өдрийн  
дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

ХЭНТИЙ АЙМГИЙН ЦАГААН САР-ЦАГААН ИДЭЭ-2024 ҮЗЭСГЭЛЭН  
ХУДАЛДААНЫ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Үүнээс: Зардлын эх үүсвэр
						ЗДТГазар
1	Шилдэг сум I байр	ш	1	300000	300000	300000
2	Шилдэг гурил гурилан бүтээгдэхүүн	ш	3	150000	450000	450000
3	Шилдэг сүү сүүн бүтээгдэхүүн	ш	3	150000	450000	450000
4	Мах, махан бүтээгдэхүүн	ш	2	150000	300000	300000
5	Шинэ Шинэлэг шийдэлтэй хүнсний бүтээгдэхүүн	ш	1	150000	150000	150000
6	Шилдэг мод модон эдлэл	ш	1	150000	150000	150000
7	Шилдэг гар урлал бэлэг дурсгал	ш	1	150000	150000	150000
8	Шилдэг үндэсний хувцас үйлдвэрлэгч	ш	1	150000	150000	150000
9	Шилдэг арьс, ширэн эдлэл	ш	1	150000	150000	150000
10	Шилдэг ногоочин, даршилсан ногоо	ш	2	150000	300000	300000
11	Өргөмжлөл	ш	16	35000	560000	560000
12	Анонс	м2	30	22000	660000	660000
13	Батламж	ш	16	8000	128000	128000
14	Талархал	ш	100	8000	800000	800000
15	Бусад зардал			102000	102000	102000
16	Заалын цэвэрлэгээ			200000	200000	200000
<b>БҮГД ҮНЭ</b>				<b>2025000</b>	<b>5000000</b>	<b>5000000</b>